

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2023/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
www.audit.mn  
Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг:  
BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-  
Amgalanm@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Батсайхан  
Утас: 70453799, Цахим хаяг:  
batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМЫН ДУЛААНЫ  
ХОЁРДУГААР СТАНЦ ТӨХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.МӨНГӨН ТАНАА

2023.03.15 № УВА-2023/03/АА-СМА-ТӨА  
танай -ны № -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг 54,093.9 мянга, борлуулалтын орлогыг 2,293.9 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн тул өглөг, борлуулалтын орлогын дансыг баталгаажуулаагүй.

Тайлант онд 1 ажилтанд цалингийн урьдчилгааг сарын цалингаас 8 дахин хэтрүүлж 7,500.0 мянган төгрөгийн олгосон, 10,600.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй, Улаангом политехник коллежтой тооцоо нийлсэн 54,093.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайлан тусгаагүй, орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг 2,293.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.8 дахь заалтад “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн

020000025

дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх”, 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “бүх өр төлбөр”, 14.4.5 дахь заалтад “бүх орлого гэж заасантай нийцэхгүй, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 464 дүгээр тогтоолоор баталсан “Улаангомын дулааны станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд гүйцэтгэх захирлын хүлээх үүрэг, хариуцлага**

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Үлдэгдэл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	33147928.04	110021021.41
1.1.2	Дансны авлага	307317713.55	267057651.50
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	277000.00	26147406.42
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	137272938.43	140815138.41
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3989700.00	6157920.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	3200000.00
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	482005280.02	553399137.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	11915421510.39	11305237363.10
1.2.2	Биет бус хөрөнгө	495880000.25	502490000.08
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12411301510.64	11807727363.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12893306790.66	12361126500.92
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.1	Дансны өглөг	532867610.37	819739477.45
2.1.1.2	Цалингийн өглөг	1791151.00	2387994.57
2.1.1.3	Татварын өр	23209600.71	20310569.21
2.1.1.4	НДШ-ийн өглөг	6759026.04	30858271.96
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	14585390.04	9756247.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	12527470.00	70047656.78
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	591740248.16	953100217.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	591740248.16	953100217.02
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	12324965430.47	13141086944.47
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	161243643.48	161243643.48
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1310608117.26	527104293.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-1495250648.71	-2421408597.11
2.3.11	Эздийн өмчийн дүн	12301566542.50	11408026283.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12893306790.66	12361126500.92

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3211446417.03	3609822409.20
2	Борлуулалтын өртөг	3055453373.79	4063676100.26
3	Нийт ашиг (алдагдал)	155993043.24	-453853691.06
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	74509461.28	106791547.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	369576661.21	721537233.49
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	3363924.04	1056.65
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	122504272.98	356025579.93
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-168952730.31	-926157948.40
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-168952730.31	-926157948.40
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-168952730.31	-926157948.40
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	-168952730.31	-926157948.40
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,670,642,581.77	4,442,934,172.95
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,490,797,330.77	3,999,959,265.18
	Татаас, санхүүжилтийн орлого	100,000,000.00	382,100,000.00
	Бусад мөнгөн орлого	79,845,251.00	60,874,907.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,598,852,473.38	4,304,192,534.12
	Ажиллагчдад төлсөн	865,986,351.00	1,097,088,088.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	297,496,504.67	315,745,268.35
	Бараа материал худалдан авахад төлсөн	634,393,363.18	943,539,535.72
	Ашиглалтын зардалд төлсөн	567,293,057.00	707,700,909.72
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	319,042,112.61	510,552,608.96
	Хүүний төлбөрт төлсөн	0	0
	Татварын байгууллагад төлсөн	332,223,920.22	295,916,938.07
	Даатгалын төлбөрт төлсөн	0	540,352.00
	Бусад мөнгөн зарлага	582,417,164.70	433,108,833.30
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	71,790,108.39	138,741,638.83
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,652,181.82	61,868,545.46
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,652,181.82	57,823,545.46
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0	4,045,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-44,652,181.82	-61,868,545.46
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
4.1	Валютын ханшийн зөрүү	0	0
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,137,926.57	76,873,093.37
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,010,001.47	33,147,928.04
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,147,928.04	110,021,021.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-1326297918.40	-1326297918.40
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	-1326297918.40	-1326297918.40
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-168952730.31	-168952730.31
Өмчид гарсан өөрчлөлт	12324965430.47	0.00	1310608117.26	0.00	13635573547.73
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	161243643.48	0.00	0.00	161243643.48
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	12324965430.47	161243643.48	1310608117.26	-1495250648.71	12301566542.50
Залруулсан үлдэгдэл	12324965430.47	161243643.48	1310608117.26	-1495250648.71	12301566542.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-926157948.40	-926157948.40
Өмчид гарсан өөрчлөлт	816121514.00	0.00	-783503824.20	0.00	32617689.80
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13141086944.47	161243643.48	527104293.06	-2421408597.11	11408026283.90

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэсэн дулаан	мян.Гкал	55.6	58.0	56.0	2.0	96.5
2	Шугамын алдагдал /биетээр/	мян.Гкал	2.8	2.90	2.80	0.10	96.5
3	Борлуулсан дулаан	мян.Гкал	52.8	55.1	53.2	1.9	96.5
4	Нийт орлого :	мян.төг	3,335,450.7	3,837,290.6	3,686,509.7	150,780.9	96.0
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	3,211,446.4	3,555,472.5	3,404,691.6	150,780.9	96.0
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	124,004.3	181,818.1	181,818.1	0.0	100
	Орон нутгаас халуун усны дэмжлэг			100,000.0	100,000.0	0.0	100
5	Нийт зардал	мян.төг	3,504,403.4	4,512,586.7	4,090,928.3	421,658.4	90.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	53,684.5	118,911.6	118,911.6	0.0	100
6	Нийт ашиг алдагдал	мян.төг	(168,952.7)	(675,296.14)	(523,330.2)	(151,965.94)	77.5
7	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.1	1.18	1.18	0.00	100
8	Нийт авлага :	мян.төг	307,594.7	138,697.2	138,697.2	0.0	100
9	Нийт өглөг :	мян.төг	591,740.2	614,962.7	614,521.2	441.5	99.9
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	591,740.2	614,962.7	614,962.7	441.5	99.9
10	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	142,788.9	521,497.4	281,497.4	239,999.6	53.9
11	Ажиллагсдын тоо	тоо	90.0	93.0	93.0	0.0	100
12	Нийт цалингийн сан	мян.төг	967,023.6	1,245,541.1	1,315,733.0	70,191.9	105.6

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК, түүний үйл ажиллагаа**

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь “Увс аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц дулааны эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, дулаан хангамжаар хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмдэг байна.

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалтай хангах

#### **3.2 Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ын гадаад, дотоод орчин**

Дулааны шугам сүлжээний шинэчлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 64/2014 тоот актаар, Станцын барилга байгууламж, зуух, даралтад сав, шугам хоолойг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 68/2014 тоот актаар тус тус Улсын комиссын хүлээн авсан.

Ашиглалтын өмнөх захиргаа нь 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 60 хүний бүтэц орон тоотойгоор ажилчдыг авч халаалтын улирлыг эхлүүлэн үйл ажиллагаагаа жигдрүүлж, ажиллах хүч ажлын байрны тодорхойлолт, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, бизнес төлөвлөгөө зэргийг гарган шинэ тутам байгууллагыг байгуулан ажиллаж байгаад 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдөр татан буугдсан.

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/67 тоот тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байгуулагдан “Дулааны хоёрдугаар станц, Дулааны шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн оноосон нэр бүхий гэрчилгээ авч 70 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ажиллаж байгаад 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр татан буугдсан.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 202 дугаар тогтоолоор “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2022 онд 9 удаа зохион байгуулж 41 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 86,222.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 66,183.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 54,500.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 11,683.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн эзэмшилд байгаа газрыг гэрчилгээтэй болгосон байна.

Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталсан Хяналт шалгалтын удирдамжийн дагуу Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тус компани дээр ажиллаж дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 109.3-т заасныг буруу хэрэглэж 2022 оны 1-4 дүгээр сард ажилтнуудын шөнийн цаг, илүү цагийн нэмэгдэл хөлсийг буруу тооцож 77.1 сая төгрөгийн илүү цалинг бодож олгосон. 2022 оны 5-р сард уг тооцооллын залруулгыг хийж, санхүүгийн тайланд 57 ажилтанд цалингийн авлага үүсгэсэн. 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар дээрх авлагын 76.1 хувь буюу нийт 58.7 сая төгрөгийн авлагыг ажиллагсдаас суутгаж, 18.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

2. Цалингийн суутгалыг хийхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн 119.2 дахь заалтыг зөрчиж, 41 ажилтны сарын цалин хөлснөөс суутгах суутгалын хэмжээ 50 хувиас хэтэрсэн.

3. 2022 оны 1-4 сарын нийгмийн даатгалын тайланд дээрх 57 ажилтны илүү олгосон цалинд ногдох 24.8 сая төгрөгийн залруулга хийж, нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг бууруулсан байна.

4. Цалингийн мэдээллийг ажиллагсад цаасаар болон цахимаар хүргэдэггүй цалин хөлсний тооцоолол, мэдээлэл хаалттай байгаа нь Хөдөлмөрийн хуулийн 104.3 дахь заалтыг зөрчиж байна. Улмаар ажиллагсад хохирох, илүү, дутуу цалин бодох нөхцөл байдалд хүргэсэн.

5. Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн 7, хамтын гэрээний 1.8, 2.2, 8.2.6, 8.6 дахь заалтуудад “... Ажил олгогч нь аж ахуй нэгж байгууллагын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны тухай мэдээлэл өгөх, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, бүтэц, зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсний асуудал зэргийг хэлэлцэхэд үйлдвэрчний эвлэлийн хорооны даргыг зөвлөх эрхтэйгээр оролцуулах, санал солилцох ...” үүргийг хүлээх гэж дүгнэсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 532,180.3 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		33,147.9	110,021.02	76,873.12
Авлага		307,317.7	267,057.6	40,260.1
Бусад авлага		277.0	26,147.4	25,870.4
Бараа материал		137,272.9	140,815.1	3,542.2
Үндсэн хөрөнгө		11,915,421.5	11,305,237.4	-610,184.1
Биет бус хөрөнгө		495,880.0	502,490.0	6,610.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>12,893,306.8</b>	<b>12,361,126.5</b>	<b>-532,180.3</b>
Өр төлбөрийн дүн		591,740.2	953,100.2	361,360.0

Эздийн өмчийн дүн	12,301,566.5	11,408,026.3	-893,540.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>12,893,306.8</b>	<b>12,361,126.5</b>	<b>-532,180.3</b>

Оны эхнээс мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 76,873.12 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд харилцах данс 109,953.1 мянга, касс 67.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын данс өмнөх оноос 4.7 хувиар буюу 66,130.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны авлагын дансны бууралт нь айл өрх, төсөвт байгууллага, аж ахуй нэгжийн дулааны авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын бусад материалын үлдэгдэл 2.6 хувь буюу 3,542.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй ба байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 610,184.1 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 170,160.9 мянга, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 780,345.1 мянган төгрөг байгуулсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 6,610.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд биет бус хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 953,100.2 мянган төгрөг болж өмнөх оны эхний өр төлбөрөөс 361,360.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, тээврийн зардал, нүүрсний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 11,408,026.3 мянган төгрөг болж 893,540.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд алдагдалтай ажилласантай холбоотой байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт нүүрсний зардал, үйлдвэрийн ажилчдын цалин, урамшуулал, хоолны хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэл, цэвэрлэгээ, сэлбэг, ус, үйлдвэрт ногдох үндсэн хөрөнгийн элэгдэл, цахилгаан, хөдөлмөр хамгаалал, шатахуун, тээврийн хөлс, засвар, түрээс, үл хөдлөх хөрөнгийн татвар, агаарын бохирдлын татвар, үнс асгах, үнс тээврийн зардлуудыг хамруулсан байна.

### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөл, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц”

ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,837,290.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,512,586.7 мянган төгрөгөөр, 675,296.14 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 521,497.4 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 3,686,509.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,404,691.6 мянган төгрөгийн зардал гарган, 523,330.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,686,509.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 150,780.9 мянган төгрөг буюу 4 хувиар буурсан бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, тээврийн зардал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,090,928.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 421,658.4 мянган төгрөг буюу 10.7 хувиар буурсан байна.

Тайлант онд алдагдал 523,330.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 151,965.9 мянган төгрөгөөр буурсан байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалингийн урьдчилгаа болон санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2023 оны 02 дугаар сарын 25-наас 2023 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Увс аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 4,892,004.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 24,460.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,568.0 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллажээ.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны татварын тайлангаарх борлуулалтын орлогын дүн, санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан байна. Уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Увс аймгийн татварын хэлтэст албан бичиг хүргүүлэхээр болов.

2. “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн Ерөнхий инженерээр ажиллаж байсан Б.Мөнгөнийг гүйцэтгэх захирлын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/102 дугаартай тушаалаар өндөр насны тэтгэвэр гарах болсон гэдэг үндэслэлээр 47,040.0 мянган төгрөгийн тэтгэмж олгож, ажлаас чөлөөлсөн байхад гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгчээр буцааж томилсон байна. Уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Төрийн албаны зөвлөлд албан бичиг хүргүүлэхээр болов.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

## **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төрийн аудитын байгууллагын 2023 оны аудитын төлөвлөгөө, Увс аймаг дахь төрийн аудитын газрын 2023 оны аудитын төлөвлөгөөнд Улаангом дулааны хоёрдугаар станц ТӨХК-ийн 2020-2022 оны үйл ажиллагааны үр дүнд /УВА-2023/46-ШТА-ГА/ аудит хийхээр тусгагдсан тул 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг санхүүгийн тайлан, журнал, дансны хуулгын түвшинд хийж гүйцэтгэсэн болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 74,487.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Тайлант онд 1 ажилтанд цалингийн урьдчилгааг сарын цалингаас 8 дахин хэтрүүлж 7,500.0 мянган төгрөгийн олгож буцаан суутгаагүй байна.
2. Ажилтнуудад олгосон 10,600.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

1. Цаашид сарын цалингаас хэтрүүлэн цалингийн урьдчилгааг олгохгүй байх.
2. Цалингийн урьдчилгааг тухай бүр суутган тооцож авлага үүсгэхгүй байх, мөн 10,600.0 мянган төгрөгийн цалингийн авлагыг барагдуулах.

#### **2. Өглөгийн данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Улаангом политехник коллежтой тооцоо нийлсэн 54,093.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайлан тусгаагүй байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Тайлант хугацааны борлуулалтын орлогыг 2,293.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

**Өгсөн зөвлөмж:**

1. Цаашид санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэж, үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Улаангом политехник коллежтой тооцоо нийлсэн 54,093.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайлан тусгаагүй байна.	1	54,093.9	1	54,093.9					1	54,093.9	1	54,093.9
Тайлант хугацааны борлуулалтын орлогыг 2,293.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	2,293.9	1	2,293.9					1	2,293.9	1	2,293.9
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>56,387.8</b>	<b>2</b>	<b>56,387.8</b>					<b>2</b>	<b>56,387.8</b>	<b>2</b>	<b>56,387.8</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант онд 1 ажилтанд цалингийн урьдчилгааг сарын цалингаас 8 дахин хэтрүүлж 7,500.0 мянган төгрөгийн олгосон.	1	7,500.0					1	7,500.0				
Ажилтнуудад олгосон 10,600.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.	1	10,600.0					1	10,600.0				
Дүн	2	18,100.0					2	18,100.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 03 сарын 15-ны өдөр